



Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 10 сарын 26 -ний өдрийн хурлын
12-р тогтоолын 1 дүгээр хавсралт

ГОВЬ ХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү Дотоод хяналтын бодлого (цаашид “Бодлого” гэх) нь Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид “Компани” гэх)-ын дотоод хяналтын тогтолцоо, баримтлах зарчмыг тодорхойлж, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Бодлогын баримт бичгийг Монгол улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс баталж, компанийн хэмжээнд үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГЫН ЗОРИЛГО

- 2.1 Бодлогын зорилго нь компанийн үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахтай холбоотой дараах харилцааг зохицуулах, нягтлан шалгах, хяналт тавихад оршино. Үүнд:
 - 2.1.1 Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмын дагуу үр ашигтайгаар удирдан явуулах;
 - 2.1.2 Компанийн эд хөрөнгийг хамгаалах, найдвартай байдлыг хангах;
 - 2.1.3 Ашиглан, залилангийн үйлдэл болон алдаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, засах;
 - 2.1.4 Нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах;
 - 2.1.5 Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бодитоор бэлтгэн гаргах;
 - 2.1.6 Эрсдэлийг тогтмол хянах, удирдах;

Гурав. ДОТООД ХЯНАЛТЫН ЗАРЧИМ

- 3.1. Компани нь дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1 **Шударга байх** – хяналт шалгалтыг явуулахдаа шударга ёсыг сахиж, шалгалтад хамрагдаж буй этгээдийг хяналт шалгалттай холбоотой аливаа асуудлаар нэмэлт тайлбар гаргах эрхээр ханган, үр дүнг шударгаар тайлагнан, шийдвэрлэх;
 - 3.1.2 **Ёс зүйд нийцсэн байх** – хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Компанийн ёс зүйн дүрмийг баримтлан, бусдын гүйцэтгэсэн ажлыг хүндэтгэн үзэх, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
 - 3.1.3 **Хуулийг сахин дээдлэх** – хяналт шалгалтын үйл ажиллагааг зөвхөн хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд явуулах;
 - 3.1.4 **Хараат бус байх** – үнэнч шударга, зөв үзэл хандлагаар хяналтыг хэрэгжүүлж, хувийн сонирхол болон компанийн чиг үүргийн хооронд зөрчил үүсгэх нөхцөл байдлаас сэргийлж, сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 3.1.5 **Бодитой бөгөөд тэгш хандах** – хяналтыг хэрэгжүүлэхдээ төвийг сахисан байр сууриас хандан, хөндлөнгийн нөлөөлөлд автахгүйгээр бодит нөхцөл

байдлыг үнэлж, шалгалтад хамрагдаж буй нэгж болон бүх түвшний ажилтнуудад эрх тэгш хандах;

- 3.1.6 **Мэргэжлийн ур чадвартай байх** – хяналтыг хэрэгжүүлэгч нь харилцааны соёлтой, зөв хандлагатай бөгөөд мэргэжлийн ур чадвартай байх;
- 3.1.7 **Нууцыг хадгалах** – хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцдаа олж авсан мэдээллийг өөрийн үүргийн хүрээнд тайлагнахаас бусад зорилгоор бусдад задруулахгүй байх;
- 3.1.8 **Тасралтгүй сайжруулдаг байх** – компанийн үйл ажиллагааг эрсдэлгүй, үнэн зөв, ил тод байлгахад чиглэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл явцыг цаг үеийн өөрчлөлттэй уялдуулан тогтмол сайжруулдаг байх;

Дөрөв. ДОТООД ХЯНАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН

- 4.1. Компанийн дотоод хяналтын тогтолцоо нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
 - 4.1.1 **Хяналтын орчин** – Компанийн хэмжээнд баримтлах ёс зүйн дүрэм, дотоод хяналтын бодлого, холбогдох дүрэм журмуудыг боловсруулан, мөрдүүлэх арга замаар үүрэг хариуцлагыг тодорхой болгон, байгууллага дахь ёс зүйн хэм хэмжээ болон шударга байдлыг төлөвшүүлэх бөгөөд удирдлагын зүгээс тогтмол оролцоотой байж хяналтын бат бөх суурийг бүрдүүлнэ .
 - 4.1.2 **Эрсдэлийн үнэлгээ** – Компани Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэн аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэхэд шаардагдахуйц нарийвчлалтайгаар зорилгоо тодорхойлох бөгөөд түүнийг биелүүлэхэд учрах эрсдэлүүдийг илрүүлэн, үнэлж, хяналтыг хэрэгжүүлнэ.
 - 4.1.3 **Хяналтын үйл ажиллагаанууд** – Компанийн хэмжээнд тодорхойлсон эрсдэлүүдийг хүлцэх түвшинд хүртэл бууруулах, удирдах арга замуудын хэрэгжилтийг шат бүртээ хангана.
 - 4.1.4 **Мэдээлэл ба харилцаа** – Компани дотоод хяналтын тогтолцооны хэвийн ажиллагааг хангахад чиглэсэн мэдээллийн боловсруулалт болон хэрэглээг хангаж, үйл ажиллагаа, санхүү, нийцлийн тайлангуудаар дамжуулж байгууллага дотор дээрээс доош, доороос дээш мөн хөндлөн чиглэлд мэдээлэл солилцоно.
 - 4.1.5 **Мониторинг** – Дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлгээг тогтмол хийн, тасралтгүй сайжруулах замаар компанийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

Тав. ДОТООД ХЯНАЛТЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

- 5.1. Компани нь дотоод хяналтыг Бүх ажилтан, Нэгжийн удирдлага, Гүйцэтгэх удирдлагын баг, Дотоод аудитын хэлтэс, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо, ТУЗ, Хөндлөнгийн аудит гэсэн шатлалтайгаар хэрэгжүүлнэ.
- 5.2. **Бүх ажилтнуудын эрх, үүрэг**
 - 5.2.1 Бүх ажилтнууд Ёс зүйн дүрмийг ойлгож ухамсарлан, өдөр тутам үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг сахиж ажиллана.



- 5.2.2 Харьяалагдах нэгжийн хувьд тодорхойлсон эрсдэл, дотоод хяналтын зорилго, үйл ажиллагаа, хүлээгдэж буй мэдээлэл харилцаа, мониторингийн үйл ажиллагааны ач холбогдлыг ухамсарлан ажиллана.
- 5.2.3 Харьяалагдах нэгжийн дотоод хяналтын журмуудыг мөрдөж ажиллана.
- 5.2.4 Хариуцсан ажлын эрсдэлийн хүчин зүйлийн өөрчлөлт, дотоод хяналтын дутагдал, зөрчлийг мэдээлэхэд идэвх, санаачилгатай байна.

5.3. Нэгжийн удирдлагын эрх, үүрэг

- 5.3.1 Дотоод хяналтын бодлого, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэхэд ажилтнуудад зааварчилгаа өгч, хэрэгжилтийг хангана.
- 5.3.2 Хариуцсан нэгжийн дотоод хяналтын орчныг бүрдүүлж, хяналтыг хэрэгжүүлнэ. Үүнд, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх багтана.
- 5.3.3 Ажилтнуудаас авсан тайлан мэдээ, мэдээлэлд үндэслэн хариуцсан нэгжийн мониторинг болон хэрэгжүүлж буй хяналтын үр дүнг үнэлнэ.
- 5.3.4 Дотоод хяналтын дутагдал, сул тал илэрвэл түүнийг тухай бүрд засах, зөрчил, дутагдлыг холбогдох албан тушаалтанд мэдээлнэ.
- 5.3.5 Гадаад болон дотоод орчин дахь өөрчлөлтөөс үүдэн хариуцаж буй нэгжийн эрсдэлийн хүчин зүйлд өөрчлөлт гарсан бол дотоод хяналт зохистой хэвээр эсэхийг авч үзэн, сайжруулалтыг холбогдох албан тушаалтанд санал болгоно.

5.4. Гүйцэтгэх удирдлагын багийн эрх, үүрэг

- 5.4.1 Компанид үр дүнтэй, зохистой дотоод хяналтын тогтолцоог үйл ажиллагааны бүх шатанд боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.4.2 Дотоод хяналтын бодлогын хүрээнд компанийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн компанийн бүтэц, тайлагнал, эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалтыг тогтооно.
- 5.4.3 ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын тодорхойлсон зорилгуудын талаарх мэдээллийг нэгжийн удирдлага, нийт ажилтнуудад ойлгомжтой байдлаар хүргэх, зорилго биелүүлэхтэй холбоотой үүрэг оролцоог нь ойлгуулахад чиглэсэн мэдээллийн урсгалыг бүрдүүлнэ.
- 5.4.4 Компани зорилгодоо хүрэхэд шаардлагатай үр чадвар бүхий хүний нөөцийг татан, хөгжүүлж, тогтвортой ажиллуулна.
- 5.4.5 Компанийн ажилтнууд болон хамтрагч байгууллагуудад дотоод хяналтын ухамсрыг төлөвшүүлж, хяналтын орчныг бүрдүүлэн, шаардлагатай тохиолдолд шинэчилж сайжруулна.
- 5.4.6 Компанийн дотоод хяналтын хэрэгжилтэд ихээхэн нөлөөлөх гадаад болон дотоод өөрчлөлтүүдийг тогтмол тодорхойлж үнэлнэ.

5.5. Дотоод аудитын хэлтсийн эрх, үүрэг

- 5.5.1 Дотоод хяналтын үйл ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан бодлого, дүрэм журмын дагуу хараат бусаар хийж гүйцэтгэнэ.
- 5.5.2 Дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны үнэлгээг хийж, үр дүнг Эрсдэл, аудитын хороонд тайлагнана.

- 5.5.3 Аудитын шалгалтын үеэр илэрсэн дотоод хяналтын зөрчил, дутагдал, сул тал, зөрчлүүдийг Эрсдэл, аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагын багт тайлагнаж, сайжруулах санал зөвлөмжийг хүргэн, хэрэгжилтэд мониторинг хийж ажиллана.
- 5.5.4 Өндөр эрсдэл бүхий хяналтын зөрчил болон бусад нөлөө бүхий дутагдлыг Эрсдэл, аудитын хороонд мэдээлнэ.
- 5.6. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны эрх, үүрэг**
- 5.6.1 Дотоод хяналтын бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хянаж, дотоод хяналтын үнэлгээг жил бүр хийж ТУЗ-д тайлагнана.
- 5.6.2 Дотоод аудитын хэлтсийн болон Эрсдэлийн удирдлагын багийн тайлантай танилцаж, санал зөвлөмж дүгнэлт өгөх, ТУЗ-ийг компанийн дотоод хяналтын үр дүнтэй холбоотой мэдээллээр хангаж ажиллана.
- 5.6.3 Шүгэл үлээгчдийн мэдээллийг зохих журмын дагуу хүлээн авч, шалгалтыг Дотоод аудитын хэлтсийн оролцоотой хараат бусаар гүйцэтгэж шийдвэрлэнэ.
- 5.7. ТУЗ-ийн эрх, үүрэг**
- 5.7.1 Дотоод хяналтын бодлогыг тодорхойлж батлан, шаардлагатай гэж үзвэл сайжруулалт шинэчлэлтийг манлайлна.
- 5.7.2 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан компанийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.
- 5.7.3 Компанийн дотоод хяналтын тогтолцоог үнэлж дүгнэхдээ Гүйцэтгэх удирдлагаас хараат бус байна.
- 5.7.4 Оролцогч талууд (хувьцаа эзэмшигч, харилцагчид, хэрэглэгчид, бэлтгэн нийлүүлэгчид, ажилтнууд, зохицуулагч байгууллагууд)-тай тогтмол үр дүнтэй харилцаа холбоотой байх бөгөөд Гүйцэтгэх удирдлагаар дамжихгүйгээр ТУЗ-тэй холбоо тогтоох, мэдээлэл хүргэх, шүгэл үлээх боломжийг бүрдүүлнэ.
- 5.8. Хөндлөнгийн аудитын эрх, үүрэг**
- 5.8.1. Компанийн дотоод хяналтын материаллаг алдаа, дутагдлыг Эрсдэл, аудитын хороо, Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэж, сайжруулах санал зөвлөмжөөр хангана.

Зургаа. БУСАД

- 6.1. Энэхүү бодлого нь ТУЗ-ийн хурлаар баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.2. Бодлогод ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос гаргасан саналд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдлэх бөгөөд тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулан баталснаар энэхүү бодлогын нэгэн адил даган мөрдөгдөнө.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ